



КРЕДИТ
ББСБ

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 3 сарын 16-ны өдөр

№2020/5

Улаанбаатар хот

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг
цахимаар зарлан хуралдуулах тухай

Компанийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1, 60.2, 60.4 дэх заалт, 62 дугаар зүйлийн 62.1.9, 62.1.14 дэх заалт, 65 дугаар зүйлийн 65.1, 65.3, 65.4, 65.6 дахь заалт, 67 дугаар зүйлийн 67.1, 67.5 дахь заалт, 71 дүгээр зүйлийн 71.1, 71.3 дахь хэсэг, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам”, Санхүүгийн Зохицуулах Хорооны 3 сарын 4-ний өдрийн “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зохион байгуулах тухай зөвлөмж”, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 3 сарын 16-ны өдрийн эцнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (цаашид “Хурал” гэх)-ыг 2020 оны 4 сарын 25-ны өдрийн 12.00 цагт www.live.ard.mn цахим хуудсыг ашиглан цахим хэлбэрээр зарлан хуралдуулсугай.
2. Хурлыг зарлах тухай мэдэгдлийг 2020 оны 3 сарын 19-ний өдрийн дотор Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Биржид тус тус хүргүүлсүгэй.
3. Хурал хуралдуулах тухай зар мэдээг Монголын Хөрөнгийн Биржийн цахим хуудас, өдөр тутмын хоёроос доошгүй сонин болон бусад хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан 2020 оны 3 сарын 20-ны өдрийн дотор нийтэд мэдээлж, уг зарын давталтыг 2020 оны 4 сарын 3-ны өдөр анх зарласан хэлбэрээр дахин нийтэд мэдээлсүгэй.
4. Хуралд оролцох эрхтэй Хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2020 оны 4 сарын 8-ны өдрөөр тогтоосугай.
5. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалт, гарах шийдвэрийн төсөл, танилцуулга, саналын хуудас зэрэг бусад холбоотой баримт бичгийг 2020 оны 3 сарын 25-ны өдөрт багтаан үнэт цаасны брокер, дилерийн компаниудад хүргүүлсүгэй.
6. Хурлын даргаар Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуягийг томилсугай.

7. Дараах нэр бүхий хүмүүсийг Хурал зохион байгуулах комиссын бүрэлдэхүүнээр томилсугай. Үүнд:

Хурал зохион байгуулах комиссын дарга:

Гүйцэтгэх захирал Г.Тэлмэн

Хурал зохион байгуулах комиссын гишүүд:

Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга М.Мөнхсүрэн

Үйл ажиллагаа эрхэлсэн менежер М.Номин-Эрдэнэ

Стратеги, бодлого төлөвлөлт эрхэлсэн захирал Г.Сүхбаатар

Ерөнхий нягтлан бодогч Д.Дархижав

8. Хурлаар хэлэлцэх асуудлын жагсаалтыг нэгдүгээр хавсралтаар, саналын хуудасны загварыг хоёрдугаар хавсралтаар, Хурлын нийтэд хүргэх зарын загварыг гуравдугаар хавсралтаар, Хурлаар хэлэлцэх асуудалтай холбоотой материалын жагсаалтыг дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.
9. Санал авах хуудсаар урьдчилж санал өгөх сүүлчийн хугацааг 2020 оны 4 сарын 24-ний өдрийн 11:00 цагаар тасалбар болгосугай.
10. Хувьцаа эзэмшигчдийг Хурлын материалтай танилцах нөхцөл, боломжийг бүрдүүлж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Г.Тэлмэн/-т даалгасугай.
11. Хурлын Тооллогын комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсугай. Үүнд:
Тооллогын комиссын дарга: Г.Алтансүх (Блүмсбюри Секьюритиз ҮЦК ХХК)
Тооллогын комиссын гишүүд: Д.Энхзориг, Б.Мөнхзул (Блүмсбюри Секьюритиз ҮЦК ХХК)
12. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар мэдээг хүргэх, хувьцаа эзэмшигчдийг шаардлагатай мэдээллээр хангаж ажиллахыг Хурал зохион байгуулах комисс /Г.Тэлмэн/-д даалгасугай.
13. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шийдвэрлэсэн асуудал болон бусад материалыг Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасан хугацаанд Монголын Хөрөнгийн Бирж, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэхийг хурлын дарга Ч.Ганхуяг болон Хурал зохион байгуулах комиссын дарга Г.Тэлмэн нарт даалгасугай.

ДАРГА



Ч.ГАНХУЯГ

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 3 сарын 16-ны өдрийн
2020/5 тоот тогтоолын Хавсралт №1



**2020 ОНЫ 4 САРЫН 25-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛЫН ЖАГСААЛТ**

1. 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
2. 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 3 сарын 16-ны өдрийн
2020/5 тоот тогтоолын Хавсралт №2

**АРД КРЕДИТ ББСБ ХК
САНАЛ АВАХ ХУУДАС
(ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ №2)**

Хувьцаа эзэмшигчийн овог, нэр: _____

Регистрийн дугаар: _____

Эзэмшиж буй хувьцааны төрөл: энгийн

Эзэмшиж буй хувьцааны тоо: _____

Энэхүү санал авах хуудсаар 2020 оны 4 сарын 25-ны өдрийн 12:00 цагт компанийн www.live.ard.mn сайтаар дамжуулан хуралдах Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд санал өгнө.

№	Хурлаас гарах шийдвэрийн томьёолол	Зөвшөөрсөн	Татгалзсан	Түдгэлзсэн
1	Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх төлөөлөн удирдах зөвлөлийн гаргасан дүгнэлтийг баталсугай.	☐	☐	☐

1. Та саналын хуудсыг бөглөхдөө өөрийн сонгож буй хэсэгт ✓ тэмдгийг бичнэ үү.
2. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Ард Холдингсын байр, 2 давхарт ирж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар урьдчилан саналаа өгнө.
3. Хэрэв өөр хүнээр төлөөлүүлэх бол төлөөлөх хүндээ итгэмжлэл олгож, нотариатаар баталгаажуулсан байх ба уг итгэмжлэл нь зөвхөн тухайн хурлын өдөр хүчинтэй байна.
4. Хувьцаа эзэмшигч нь хувь хүн бол саналын хуудас дээр гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд хэрэв хуулийн этгээд бол эрх бүхий этгээд гарын үсэг зурж болон хуулийн этгээдийн тэмдгийг дарж баталгаажуулсан байна

Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг _____

Санал авах хуудсыг үйлдсэн 2020 оны .. сарын .. өдөр

Саналын хуудсыг хүчинтэйд тооцон тоолсон эсэх: Тийм/Үгүй

Тооллогын комиссын дарга _____ /...../

Хүчингүйд тооцсон бол шалтгаан: _____



Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 3 сарын 16-ны өдрийн
2020/5 тоот тогтоолын Хавсралт №3

АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН АНХААРАЛД

Ард Кредит ББСБ ХК нь шинэ төрлийн коронавирусын /CoVid-19/ болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх үүднээс Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг цахим хэрэгсэл ашиглан хуралдуулахаар боллоо. Хувьцаа эзэмшигч та хурлын өдөр www.live.ard.mn цахим хуудсаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралдаа оролцоно уу.

Компанийн оноосон нэр: Ард Кредит ББСБ ХК

Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2020 оны 3 сарын 16-ны өдрийн 2020/5 тоот тогтоолын дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах тухай зарлаж байна.

Хурал хуралдуулах өдөр, цаг: 2020 оны 4 сарын 25-ны өдрийн 12:00 цагт www.live.ard.mn сайтаар дамжуулан хуралдана. Та цахим хуралд оролцоходоо регистрийн дугаараа ашиглан сайтад нэвтэрнэ үү.

Хурлаар дараах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Үүнд:

- 1.1. Компанийн 2020 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг танилцуулах;
- 1.2. Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлтийг батлах;

Бүртгэлийн өдөр: 2020 оны 4 сарын 8

Хуралд бэлтгэх явцад Хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох баримт бичгийн жагсаалт:

1. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. Компанийн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гаргасан дүгнэлт;
3. Хурлаар хэлэлцэх асуудалд санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчийн хурлын тогтоолын төсөл.

Хувьцаа эзэмшигч та 2020 оны 4 сарын 25-ны өдрөөс өмнө ажлын өдрүүдэд 09:00-18:00 цагийн хооронд Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхарт ирж, эсвэл компанийн www.ardcredit.com цахим хуудсаар хурлын материалтай танилцах боломжтой.

Хурлын талаар дэлгэрэнгүй мэдээллийг компанийн байранд болон хурал зохион байгуулах комиссын утсаар холбогдон авна уу.

Хаяг: Сүхбаатар дүүрэг, Ерөнхий сайд Амарын гудамж-2, Ард Санхүүгийн Нэгдлийн байр, 2 давхар
Утас: 77003322

ХУРАЛ ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИСС

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн
2020 оны 3 сарын 16-ны өдрийн
2020/5 тоот тогтоолын Хавсралт №4



**2020 ОНЫ 4 САРЫН 25-НЫ ӨДӨР ХУРАЛДАХ
АРД КРЕДИТ ББСБ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ
ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛТАЙ ХОЛБООТОЙ МАТЕРИАЛ**

1. 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан;
2. 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх Төлөөлөн Удирдах Зөвлөлийн Дүгнэлт;
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар санал өгөх Саналын хуудасны загвар;
4. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын дэг;
5. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тогтоолын төсөл;

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн 377 дугаар тогтоолоор баталсан "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам"-ын нэгдүгээр Хавсралт



ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН МЭДЭГДЭЛ

Компанийн нэр	Ард Кредит ББСБ ХК
Хаяг	Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж 2, Ард Холдингс байр, 2 давхар
Хурал хуралдах өдөр, цаг	2020 оны 4 сарын 25-ны өдөр, 12:00 цаг
Хурал хуралдах газар /хаяг, байршил/	www.live.ard.mn цахим хуудсаар
Хурлын төрөл	Ээлжит
Хурал зарлагч	Төлөөлөн Удирдах Зөвлөл
Хурал хуралдах шийдвэр гаргасан огноо	2020 оны 3 сарын 16-ны өдөр
Олон нийтэд зарлах огноо	2020 оны 3 сарын 20-ны өдөр
Бүртгэлийн өдөр	2020 оны 4 сарын 8-ны өдөр
Гэрээний дагуу хурлын баримт, бичгийг брокер, дилерийн компанид хүргүүлэх огноо	2020 оны 3 сарын 25-ны өдөр
Хүргүүлсэн огноо	2020 оны 3 сарын 19-ний өдөр
Хурлын даргын нэр	Чулуун овогтой Ганхуяг
Тооллогын комиссын дарга, гишүүдийн нэрс	Комиссын дарга: Г.Алтансүх Комиссын гишүүн: Д.Энхзориг Комиссын гишүүн: Б.Мөнхзул
Баримт, бичгийн жагсаалт	Хавсралтаар
Баримт, бичгийн хуудасны тоо	

Хурал зохион байгуулах комиссын дарга



/Г.Тэлмэн/



КРЕДИТ
ББСБ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 4 сарын 25-ны өдөр

№01/20

Улаанбаатар хот

2019 оны үйл ажиллагааны болон
санхүүгийн тайланг батлах тухай

Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1.9 дэх хэсэг, 2020 оны 4 сарын 25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын Тооллогын комиссын 20/01 тоот тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Ард Кредит ББСБ ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэсэн 2019 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хавсралтаар баталсугай.

ХУРЛЫН ДАРГА

Ч.ГАНХУЯГ